| | <i>Шилжих</i> | | | | | | 976.7 | 476.7 | |
| XXII.3.4 | Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /Хөвсгөл/ | УТ2402002282 | 2024 | 2025 | 1,000.0 | 1,000.0 | 976.7 | 476.7 | |
| XXIII | АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА | | | | | | 2,360.9 | 2,360.9 | |
| XXIII.2 | II. Их засвар | | | | | | 979.2 | 979.2 | |
| | <i>Шинэ</i> | | | | | | 979.2 | 979.2 | |
| XXIII.2.1 | Авлигатай тэмцэх газрын барилгын их засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ | УТ2503300022 | 2025 | 2025 | | | 979.2 | 979.2 | |
| XXIII.3 | III. Тоног төхөөрөмж | | | | | | 1,381.7 | 1,381.7 | |

| | | | | | | | | | | | |
|---------------|---|---------------|------|------|--|--|--|--|--|------------------|-----------------|
| | Шинэ | | | | | | | | | 1,381.7 | 1,381.7 |
| XXIII.3.1 | Авлигатай тэмцэх газрын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ | УТ25033000016 | 2025 | 2025 | | | | | | 1,381.7 | 1,381.7 |
| XXIV | УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ | | | | | | | | | 6,545.2 | 4,628.2 |
| XXIV.1 | I. Барилга байгууламж | | | | | | | | | 2,493.0 | 576.0 |
| | Шинэ | | | | | | | | | 2,493.0 | 576.0 |
| XXIV.1.1 | Улсын дээд шүүхийн цахим систем /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ | УТ2500400004 | 2025 | 2026 | | | | | | 2,493.0 | 576.0 |
| XXIV.3 | III. Тоног төхөөрөмж | | | | | | | | | 4,052.2 | 4,052.2 |
| | Шинэ | | | | | | | | | 4,052.2 | 4,052.2 |
| XXIV.3.1 | Улсын дээд шүүхийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ | УТ2500400002 | 2025 | 2025 | | | | | | 3,887.2 | 3,887.2 |
| XXIV.3.2 | Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ | УТ2500400008 | 2025 | 2025 | | | | | | 165.0 | 165.0 |
| XXV | ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА | | | | | | | | | 144,145.7 | 62,984.5 |
| XXV.1 | I. Барилга байгууламж | | | | | | | | | 127,925.6 | 46,764.4 |
| | Шинэ | | | | | | | | | 51,970.7 | 18,769.1 |
| XXV.1.1 | Архангай аймаг дахь шүүхийн барилга /Архангай, Эрдэнэбулган сум/ | УТ2500500005 | 2025 | 2026 | | | | | | 8,674.8 | 3,469.9 |
| XXV.1.2 | Багануур дүүрэг дэх шүүхийн барилга /Улаанбаатар, Багануур дүүрэг/ | УТ2500500010 | 2025 | 2026 | | | | | | 8,674.8 | 3,469.9 |
| XXV.1.3 | Дархан-Уул аймаг дахь шүүхийн барилга /Дархан-Уул, Дархан сум/ | УТ2500500006 | 2025 | 2026 | | | | | | 12,320.1 | 4,928.0 |



| | | | | | | | | | |
|----------|--|--------------|------|------|----------|----------|--|-----------------|-----------------|
| XXV.1.4 | Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажллагааны тойргийн анхан шатны шүүхийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ | УТ2500500012 | 2025 | 2026 | | | | 12,801.0 | 5,120.4 |
| XXV.1.5 | Өмнөговь аймаг дахь шүүхийн барилга /Өмнөговь, Далаандагд сум/ | УТ2500500013 | 2025 | 2026 | | | | 9,500.0 | 1,780.9 |
| | <i>Шилжих</i> | | | | | | | 75,954.9 | 27,995.3 |
| XXV.1.6 | Дүүргүүдийн шүүхийн нэгдсэн байр /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ | УТ1300500001 | 2013 | 2026 | 15,000.0 | 75,954.9 | | 75,954.9 | 27,995.3 |
| XXV.3 | III. Тоног төхөөрөмж | | | | | | | 16,220.1 | 16,220.1 |
| | <i>Шинэ</i> | | | | | | | 16,220.1 | 16,220.1 |
| XXV.3.1 | Шүүхийн ерөнхий зөвлөлийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Цингэлтэй дүүрэг/ | УТ2500500039 | 2025 | 2025 | | | | 16,220.1 | 16,220.1 |
| XXVI | УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР | | | | | | | 73,150.5 | 29,849.1 |
| XXVI.1 | I. Барилга байгууламж | | | | | | | 69,340.1 | 26,038.7 |
| | <i>Шилжих</i> | | | | | | | 69,340.1 | 26,038.7 |
| XXVI.1.1 | Прокурорын газрын барилга /Булган, Булган сум/ | УТ2400600050 | 2024 | 2026 | 3,941.8 | 3,941.8 | | 3,812.0 | 1,591.1 |
| XXVI.1.2 | Прокурорын газрын барилга /Сүхбаатар, Баруун-Урт сум/ | УТ2400600004 | 2024 | 2025 | 4,056.2 | 4,056.2 | | 3,975.7 | 1,947.6 |
| XXVI.1.3 | Эрүүгийн хэргийн төв архивын барилга /Улаанбаатар/ | УТ2400600051 | 2024 | 2026 | 17,000.0 | 17,000.0 | | 17,000.0 | 7,500.0 |
| XXVI.1.4 | Дүүргүүдийн прокурорын нэгдсэн байр /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ | УТ1300600001 | 2013 | 2026 | 10,000.0 | 18,931.1 | | 44,552.4 | 15,000.0 |
| XXVI.3 | III. Тоног төхөөрөмж | | | | | | | 3,810.4 | 3,810.4 |
| | <i>Шинэ</i> | | | | | | | 3,810.4 | 3,810.4 |
| XXVI.3.1 | Прокурорын салбарын тоног төрөөмж /Улсын хэмжээнд/ | УТ2500600039 | 2025 | 2025 | | | | 3,810.4 | 3,810.4 |

| | | | | | | | | | |
|-----------------|---|--------------|------|------|--|--|--|----------------|----------------|
| XXVII | МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР | | | | | | | 1,178.8 | 1,178.8 |
| XXVII.3 | III. Тоног төхөөрөмж | | | | | | | 1,178.8 | 1,178.8 |
| | <i>Шинэ</i> | | | | | | | <i>1,178.8</i> | <i>1,178.8</i> |
| XXVII.3.1 | Үндэсний аудитын газрын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ | УТ2502400016 | 2025 | 2025 | | | | 1,178.8 | 1,178.8 |
| XXVIII | САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА | | | | | | | 250.0 | 250.0 |
| XXVIII.1 | I. Барилга байгууламж | | | | | | | 250.0 | 250.0 |
| | <i>Шинэ</i> | | | | | | | <i>250.0</i> | <i>250.0</i> |
| XXVIII.1.1 | Зохицуулалттай этгээдийн эрсдэлийн үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ | УТ2502500002 | 2025 | 2025 | | | | 250.0 | 250.0 |
| XXIX | ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРООНЫ ДАРГА | | | | | | | 300.0 | 300.0 |
| XXIX.3 | III. Тоног төхөөрөмж | | | | | | | 300.0 | 300.0 |
| | <i>Шинэ</i> | | | | | | | <i>300.0</i> | <i>300.0</i> |
| XXIX.3.1 | Шүүхийн сахилгын хорооны тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ | УТ2506500004 | 2025 | 2025 | | | | 300.0 | 300.0 |
| XXX | ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСССЫН ДАРГА | | | | | | | 2,712.0 | 2,712.0 |
| XXX.3 | III. Тоног төхөөрөмж | | | | | | | 2,712.0 | 2,712.0 |
| | <i>Шинэ</i> | | | | | | | <i>2,712.0</i> | <i>2,712.0</i> |
| XXX.3.1 | Хүний эрхийн Үндэсний Комиссын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ | УТ2501600002 | 2025 | 2025 | | | | 2,712.0 | 2,712.0 |
| XXXI | ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА | | | | | | | 2,000.0 | 2,000.0 |

| | | | | | | | | | | | |
|-----------------|--|--------------|------|------|--|--|--|--|--|--------------------|--------------------|
| XXXI.3 | III. Тоног төхөөрөмж | | | | | | | | | 2,000.0 | 2,000.0 |
| | <i>Шинэ</i> | | | | | | | | | <i>2,000.0</i> | <i>2,000.0</i> |
| XXXI.3.1 | Үндэсний статистикийн хороо, орон нутгийн статистикийн байрууллагуудын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ | УТ2502600022 | 2025 | 2025 | | | | | | 2,000.0 | 2,000.0 |
| XXXII | МОНГОЛ УЛСЫН САЙД, ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА | | | | | | | | | 2,408.1 | 2,408.1 |
| XXXII.2 | II. Их засвар | | | | | | | | | 2,408.1 | 2,408.1 |
| | <i>Шинэ</i> | | | | | | | | | <i>2,408.1</i> | <i>2,408.1</i> |
| XXXII.2.1 | Хяналт үнэлгээний Үндэсний хорооны их засвар /Улаанбаатар/ | УТ2506300001 | 2025 | 2025 | | | | | | 2,408.1 | 2,408.1 |
| XXXIII | АЖ ҮЙЛДЭВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД | | | | | | | | | 984.0 | 984.0 |
| XXXIII.3 | III. Тоног төхөөрөмж | | | | | | | | | 984.0 | 984.0 |
| | <i>Шинэ</i> | | | | | | | | | <i>984.0</i> | <i>984.0</i> |
| XXXIII.3.1 | Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ | УТ2501800037 | 2025 | 2025 | | | | | | 984.0 | 984.0 |
| | НИЙТ | | | | | | | | | 9,132,160.7 | 3,124,066.0 |

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай
хуулийн 3 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2025 ОНД ЭРГЭН ТӨЛӨЛТ ХИЙХ КОНЦЕССЫН БАРИХ-ШИЛЖҮҮЛЭХ
ТӨРЛӨӨР ХЭРЭГ ЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

| Хуулийн дугаар | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | Төслийн код | Хугацаа | | Төсөвт өртөг | | | Санхүүжих дүн |
|-------------------|--|------------------|---------|--------|--------------|-----------|-------------|------------------|
| | | | Эхлэх | Дуусах | Анхны | Сүүлийн | 2025 онд | |
| I | МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД | | | | | | 298,384.7 | 107,132.1 |
| I.1 | Эдийн засаг, хөгжлийн яам | | | | | | 298,384.7 | 107,132.1 |
| I.1.1 | I. Барилга байгууламж | | | | | | 298,384.7 | 107,132.1 |
| | <i>Шилжих</i> | | | | | | 298,384.7 | 107,132.1 |
| I.1.1.1 | Дархан-Сэлэнгийн авто замаас Шаамар- Зүүнбүрэн- Цагааннуур-Түшиг- Зэлтэрийн боомт чилтэлийн хатуу хучилттай авто зам, 120.85 км /Дархан, Сэлэнгэ, Шаамар, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг, Зэлтэр сум/ | KO24066 00089 | 2024 | 2026 | 287,401.2 | 287,401.2 | 287,401.2 | 96,148.6 |



| | | | | | | | | |
|-------------|---|-----------------|------|------|--|--|------------------|------------------|
| I.1.1.2 | Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам төслийн шүүхийн шийдвэрийн дагуу хийгдэх эргэн төлөлт /Баянхонгор/ | КО20050 0047 | 2021 | 2025 | | | 10,983.5 | 10,983.5 |
| НИЙТ | | | | | | | | |
| | | | | | | | 298,384.7 | 107,132.1 |

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3 дугаар зүйл.Нийгмийн даатгалын санд 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлогыг төвлөрүүлнэ:

| Д/д | Орлогын төрөл | Дүн /сая төгрөгөөр/ |
|--------------------|--|------------------------|
| 1 | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд | 6,927,203.2 |
| 1.1 | Ажил олгогчийн төлөх шимтгэл | 2,835,281.0 |
| 1.2 | Ажиллагчдаас төлөх шимтгэл | 2,285,157.4 |
| 1.3 | Эхийн хүүхэд асрах чөлөөтэй хугацааны шимтгэл | 14,543.1 |
| 1.4 | Цаатан иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл | 146.6 |
| 1.5 | Сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэл | 294,322.0 |
| 1.6 | Гадаадад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн төлөх шимтгэл | 6,158.8 |
| 1.7 | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн төлөх шимтгэл | 2,353.8 |
| 1.8 | Бусад орлого | 36,740.6 |
| 1.9 | Төр хариуцах иргэдийн тэтгэвэр болон шимтгэлийн хөнгөлөлтийн татаас | 1,452,499.9 |
| Нийт орлого | | 6,927,203.2 |

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3 дугаар зүйл. Эрүүл мэндийн даатгалын санд 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлогыг төвлөрүүлнэ:

| Д/д | Орлогын төрөл | Дүн /сая төгрөгөөр/ |
|--------------------|---|------------------------|
| 1 | Эрүүл мэндийн сайд | 2,514,881.8 |
| 1.1 | Ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл | 1,145,715.8 |
| 1.2 | Төрөөс эрүүл мэндийн даатгалыг нь хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл | 353,036.7 |
| 1.3 | Төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт | 966,297.8 |
| 1.4 | Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл | 49,831.5 |
| Нийт орлого | | 2,514,881.8 |

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “2024 онд 20” гэсний дараа “, 2025 онд 40” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

Индрига Fido_02 Нө||

Хүндэтгэн захирагч / ᠬᠦᠨᠳᠦᠭᠦᠨ ᠬᠠᠵᠢᠷᠠᠭᠴᠢ /

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/22 дугаар зүйлийн 22.5.22 дахь заалт:

“22.5.22.албан татвар төлөгчийн 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш хэрэгжүүлэх Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд заасан импортыг орлох, экспортыг дэмжих төслийн үндсэн үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг орлого олж эхэлсний дараагийн тайлант хугацаанаас эхлэн 5 жилийн хугацаанд 90 хувиар.”

2/22 дугаар зүйлийн 22.9.11 дэх заалт:

“22.9.11.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдийн хуульд заасан үйл ажиллагаа.”

3/22 дугаар зүйлийн 22.14, 22.15 дахь хэсэг:

“22.14.Энэ хуулийн 22.5.22-т заасан хөнгөлөлтийг мөн хуулийн 22.1, 22.5-д заасан үйл ажиллагааны орлогод үзүүлэх хөнгөлөлттэй давхардуулан эдлэхгүй.

22.15.Энэ хуулийн 22.5.22-т заасан импортыг орлох, экспортыг дэмжих салбар, үйл ажиллагаа, төслийн жагсаалтыг Улсын Их Хурал батална.”

4/27 дугаар зүйлийн 27.11 дэх хэсэг:

“27.11.Энэ хуулийн 27.1.6-д заасан гадаад валюттай харьцах төгрөгийн ханшийг Монголбанкнаас зарласан тухайн татварын жилийн дунджаар тооцож, дараагийн татварын жилийн 01 дүгээр сард багтаан татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага өөрийн цахим хуудсанд байршуулж, олон нийтэд мэдээлнэ.”



2 дугаар зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9.6 дахь заалтын “Монголын үндэсний олимпын хорооны” гэснийг “Монголын үндэсний олимпын хороо, Монголын үндэсний паралимпын хорооны” гэж, 26 дугаар зүйлийн 26.15 дахь хэсгийн “22.5.16-д” гэснийг “22.5.16, 22.5.22-т” гэж, 27 дугаар зүйлийн 27.1.6 дахь заалтын “1.7 их наяд” гэснийг “750 сая евротой тэнцэх” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.18, 15.1.19 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

5 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 22 дугаар зүйлийн 22.5.22 дахь заалт, 3 дахь заалт буюу 22 дугаар зүйлийн 22.14, 22.15 дахь хэсэг, 2 дугаар зүйлийн 26.15 дахь хэсгийн өөрчлөлтийг 2030 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд, 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 22 дугаар зүйлийн 22.9.11 дэх заалтыг 2035 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд тус тус дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.АМАРБАЯСГАЛАН



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/38 дугаар зүйлийн 38.1.26 дахь заалт:

“38.1.26.энэ хуулийн 40.8-д заасны дагуу тогтоосон ажлын үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах барилгын материал, тоног төхөөрөмж.”

2/38 дугаар зүйлийн 38.4-38.7 дахь хэсэг:

“38.4.Газар тариалангийн болон боловсруулах үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийн иж бүрдэл, трактор, комбайны импортын барааны гаалийн албан татварыг 100 хувь хөнгөлнө.

38.5.Энэ хуулийн 38.4-т заасны дагуу импортоор оруулсан бараанд тухайн онд ногдуулан төлсөн гаалийн албан татварыг дараагийн төсвийн жилийн эхний хагас жилд татвар төлөгчид буцаан олгоно.

38.6.Энэ хуулийн 38.4-т Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.8.1-22.8.8-д заасан салбар хамаарахгүй.

38.7.Энэ хуулийн 38.4-т заасан татварын хөнгөлөлтөд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8.1-д заасны дагуу баталсан Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал, түүний тодорхойлолтыг баримтална.”

2 дугаар зүйл. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсгийн “чөлөөлөх” гэсний дараа “, хөнгөлөх” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн гарчгийн “чөлөөлөгдөх” гэснийг “чөлөөлөх, хөнгөлөх” гэж өөрчилсүгэй.



4 дүгээр зүйл. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.8 дахь хэсгийн “гаалийн болон” гэснийг хассугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 38 дугаар зүйлийн 38.1.26 дахь заалт, 4 дүгээр зүйл буюу 40 дүгээр зүйлийн 40.8 дахь хэсэгт оруулсан өөрчлөлтийг 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөнө.

6 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 38 дугаар зүйлийн 38.4, 38.5, 38.6, 38.7 дахь хэсэг, 2 болон 3 дугаар зүйлийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2030 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд тус тус дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.АМАРБАЯСГАЛАН

Индюк Фидо на Холл

Индюк Фидо на Холл

Индюк Фидо на Холл

Индюк Фидо на Холл

Индюк Фидо на Холл

Индюк Фидо на Холл

Индюк Фидо на Холл

Индюк Фидо на Холл

Индюк Фидо на Холл

Индюк Фидо на Холл

«Көптөгөн мәтн...тәңгиләрнең һәр мәтн...тәңгиләрен һәр мәтн...тәңгиләрен һәр мәтн...тәңгиләрен һәр мәтн...тәңгиләрен»

«Көптөгөн мәтн...тәңгиләрнең һәр мәтн...тәңгиләрен һәр мәтн...тәңгиләрен һәр мәтн...тәңгиләрен»

«Көптөгөн мәтн...тәңгиләрнең һәр мәтн...тәңгиләрен һәр мәтн...тәңгиләрен һәр мәтн...тәңгиләрен»

«Көптөгөн мәтн...тәңгиләрнең һәр мәтн...тәңгиләрен һәр мәтн...тәңгиләрен һәр мәтн...тәңгиләрен»

«Көптөгөн мәтн...тәңгиләрнең һәр мәтн...тәңгиләрен һәр мәтн...тәңгиләрен һәр мәтн...тәңгиләрен»

«Көптөгөн мәтн...тәңгиләрнең һәр мәтн...тәңгиләрен һәр мәтн...тәңгиләрен һәр мәтн...тәңгиләрен»

Республика Латвия
Генеральный директор



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

ГААЛИЙН АЛБАН ТАТВАРЫГ ХӨНГӨЛӨХ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр баталсан Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

Mongolian Folio_02 No111

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨ ᠠᠯᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨ ᠠᠯᠤᠯᠤᠰ

ᠲᠤᠭᠤᠨ ᠬᠡᠭᠦᠨ ᠠᠯᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨ ᠠᠯᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨ ᠠᠯᠤᠯᠤᠰ

ᠲᠤᠭᠤᠨ ᠬᠡᠭᠦᠨ ᠠᠯᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨ ᠠᠯᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨ ᠠᠯᠤᠯᠤᠰ

ᠲᠤᠭᠤᠨ ᠬᠡᠭᠦᠨ ᠠᠯᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨ ᠠᠯᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨ ᠠᠯᠤᠯᠤᠰ

ᠲᠤᠭᠤᠨ ᠬᠡᠭᠦᠨ ᠠᠯᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨ ᠠᠯᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨ ᠠᠯᠤᠯᠤᠰ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21¹ дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 11-14 дэх хэсэг нэмсүгэй:

“11. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах тохиолдолд тухайн төрийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, эсхүл татан буулгах саналыг Засгийн газарт хүргүүлнэ:

1/энэ хуулийн 21¹ дүгээр зүйлийн 3¹-д заасны дагуу эцэслэн тохирсон зорилтын саналын хэрэгжилт гурван жил дараалан хангалтгүй гэж дүгнэгдсэн;

2/үйлдвэрлэлийг өргөжүүлэх, технологийг шинэчлэхэд хөрөнгө оруулснаас бусад тохиолдолд гурван жил дараалан санхүүгийн алдагдал хүлээсэн.

12. Төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын хуулийн этгээдээр аудит хийлгэж болно. Тухайн санхүүгийн жилд аудит хийлгэх төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт болон аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах этгээдийг Засгийн газар тогтооно.

13. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4, 6.8 дахь хэсэг, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээлэл болон дараах мэдээллийг хуульд заасан хугацаанд, мөн тэдгээрт өөрчлөлт оруулсан тухай бүрд өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ:

1/хуулийн этгээдийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв, менежментийн төлөвлөгөө;

2/хуулийн этгээдийн зарласан болон гаргасан, эргүүлэн худалдан авсан хувьцааны тоо, төрөл, нэрлэсэн үнэ, өөрийн хөрөнгийн хэмжээ, биет, биет бус хөрөнгийн талаарх мэдээлэл;

3/хуулийн этгээдийн сүүлийн таван жилд хөндлөнгийн аудит хийлгэсэн санхүүгийн тайлан;



4/хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны төлөвлөгөө;

5/хуулийн этгээдийн байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийн талаарх мэдээлэл;

6/хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийг үнэлэх санхүүгийн болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, гэрээ, түүний гүйцэтгэлийг дүгнэсэн мэдээлэл, гүйцэтгэх удирдлагын гэрээг сунгах эсэх тухай гаргасан шийдвэр;

7/хуулийн этгээдийн эсрэг, эсхүл хуулийн этгээдтэй холбогдуулан гаргасан нэхэмжлэл, хэрэг маргаан, хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн хуульч, өмгөөлөгч, хуулийн этгээдийн талаарх мэдээлэл;

8/хуулийн этгээдийн дүрэм, хуулийн этгээдийн үйл ажиллагааны болон засаглалын дотоод журам;

9/тухайн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын мэдээлэл, хэрэгжилтийн байдал;

10/бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын болон нийлүүлэгч этгээдийн талаарх мэдээлэл, гэрээний хугацаа, үнийн дүн, сонгон шалгаруулалтын аргачлал, хэрэгжилтийн явц;

11/Төрийн болон албаны нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хуульд заасан нууц болон холбогдох бусад хуульд заасан хаалттай, хязгаарлалттай мэдээлэл агуулаагүй төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр;

12/байгууллагын нууцад хамааруулсан мэдээллийн жагсаалт;

13/тухайн санхүүгийн жилд төлсөн албан татвар, төлбөр, хураамж;

14/төсвөөс болон бусад эх үүсвэрээс авсан дэмжлэг, хандив, тусламж.

14.Энэ зүйлийн 13 дахь хэсэгт заасан мэдээллийг нийтэд мэдээлэх, эрх бүхий байгууллагад тайлагнах үүргийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээнд тусгана.”

2 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**“79 дүгээр зүйл.Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн
эд хөрөнгийн эрх**

Орон нутгийн өмчит хуулийн этгээд энэ хуулийн 14, 16, 17, 21 дүгээр зүйл, 21¹ дүгээр зүйлийн 13 дахь хэсэгт заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.”

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.АМАРБАЯСГАЛАН



Мэдээлэл - 02

2024 оны 10 сарын 26 өдөр / 10 сарын 26 өдөр /

МОНГОЛЫН УЛАС

Улаанбаатар хотноо
МОНГОЛЫН УЛАСЫН
МОНГОЛЫН УЛАСЫН
МОНГОЛЫН УЛАСЫН

2024 оны 10 сарын 26 өдөр / 10 сарын 26 өдөр /
МОНГОЛЫН УЛАСЫН
МОНГОЛЫН УЛАСЫН
МОНГОЛЫН УЛАСЫН

2024 оны 10 сарын 26 өдөр / 10 сарын 26 өдөр /
МОНГОЛЫН УЛАСЫН
МОНГОЛЫН УЛАСЫН
МОНГОЛЫН УЛАСЫН

2024 оны 10 сарын 26 өдөр / 10 сарын 26 өдөр /
МОНГОЛЫН УЛАСЫН
МОНГОЛЫН УЛАСЫН
МОНГОЛЫН УЛАСЫН

2024 оны 10 сарын 26 өдөр / 10 сарын 26 өдөр /
МОНГОЛЫН УЛАСЫН
МОНГОЛЫН УЛАСЫН
МОНГОЛЫН УЛАСЫН

2024 оны 10 сарын 26 өдөр / 10 сарын 26 өдөр /
МОНГОЛЫН УЛАСЫН
МОНГОЛЫН УЛАСЫН
МОНГОЛЫН УЛАСЫН

2024 оны 10 сарын 26 өдөр / 10 сарын 26 өдөр /
МОНГОЛЫН УЛАСЫН
МОНГОЛЫН УЛАСЫН
МОНГОЛЫН УЛАСЫН



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн хэмнэлтийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг:

“10.2.Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно.”

2/15 дугаар зүйлийн 15.1.8 дахь заалт:

“15.1.8.байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах.”

3/15 дугаар зүйлийн 15.2.7 дахь заалт:

“15.2.7.сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх.”

2 дугаар зүйл.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“15.2.4.цахим гарын үсэг, цахим шуудан ашиглах зэргээр албан бичиг боловсруулах, илгээх үйл явцыг хялбаршуулж бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хор, шуудан хүргэлтийн зардлыг хэмнэх;”

3 дугаар зүйл.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “15.1.4-г” гэснийг “15.1.4, 15.1.8-д” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

Материалы Фольклорного собрания

Сборники фольклора

№ 25 - Собрание фольклора 2024 г.

Сборник фольклора
Сборники фольклора

6. Сборник фольклора... Собрание фольклора 2024 г.

Сборники фольклора

«Сборники фольклора... Собрание фольклора 2024 г.»
Сборники фольклора... Собрание фольклора 2024 г.

Сборники фольклора

«Сборники фольклора... Собрание фольклора 2024 г.»

Сборники фольклора

«Сборники фольклора... Собрание фольклора 2024 г.»
Сборники фольклора... Собрание фольклора 2024 г.

Сборники фольклора... Собрание фольклора 2024 г.

«Сборники фольклора... Собрание фольклора 2024 г.»
Сборники фольклора... Собрание фольклора 2024 г.

«Сборники фольклора... Собрание фольклора 2024 г.»

6. Сборник фольклора... Собрание фольклора 2024 г.

Сборники фольклора

Сборники фольклора



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 12 дугаар
сарын 06-ны өдөр

Дугаар 49

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.14 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Монгол Улсын Их Хуралд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн зарим зүйл, хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Соёлын тухай хуулийн зарим хэсэг, заалт хүчингүй болсонд тооцох тухай, Кино урлагийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 12 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар 50

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.12 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Монгол Улсын Их Хуралд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг буцаах нь зүйтэй гэсэн Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН



Бүтээгчдийн эрх зөрчил
гэрээний үндэслэл

Бүтээгчдийн эрх зөрчил гэрээний үндэслэл...

Бүтээгчдийн эрх зөрчил гэрээний үндэслэл...
Бүтээгчдийн эрх зөрчил гэрээний үндэслэл...
Бүтээгчдийн эрх зөрчил гэрээний үндэслэл...
Бүтээгчдийн эрх зөрчил гэрээний үндэслэл...
Бүтээгчдийн эрх зөрчил гэрээний үндэслэл...

Бүтээгчдийн эрх зөрчил гэрээний үндэслэл...
Бүтээгчдийн эрх зөрчил гэрээний үндэслэл...
Бүтээгчдийн эрх зөрчил гэрээний үндэслэл...
Бүтээгчдийн эрх зөрчил гэрээний үндэслэл...
Бүтээгчдийн эрх зөрчил гэрээний үндэслэл...

Бүтээгчдийн эрх зөрчил гэрээний үндэслэл...
Бүтээгчдийн эрх зөрчил гэрээний үндэслэл...
Бүтээгчдийн эрх зөрчил гэрээний үндэслэл...
Бүтээгчдийн эрх зөрчил гэрээний үндэслэл...
Бүтээгчдийн эрх зөрчил гэрээний үндэслэл...

Идэвхтэй Фолд - 02 Year Horik on Document



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 51

Улаанбаатар
хот

Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Өрийн удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2025 онд Өрийн удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.3-д заасан зориулалтаар 300.0 тэрбум төгрөг хүртэлх дотоод үнэт цаас, мөн зүйлийн 12.1.4-т заасан зориулалтаар 1.0 тэрбум ам.доллар хүртэлх гадаад үнэт цаас гаргах асуудлыг Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт нийцүүлэн шийдвэрлэх эрхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т олгосугай.

2. Энэ тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.АМАРБАЯСГАЛАН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 52

Улаанбаатар
хот

Засгийн газарт чиглэл өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төсөв, санхүү, татварын орчныг боловсронгуй болгож олон улсын стандартад нийцүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт нөлөөлж байгаа хүчин зүйлийг судалж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн олгох, бүртгэх, шилжүүлэх, хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөө, тэдгээрийн гүйцэтгэл, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн шийдвэр, техник, эдийн засгийн үндэслэл зэрэг мэдээллийг агуулсан ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлийн мэдээллийн төрөлжсөн цахим санг бүрдүүлж, улсын бүртгэлийн байгууллага, татварын байгууллагатай харилцан мэдээлэл солилцох үйл ажиллагааг боловсронгуй болгох;

2/нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх босгын хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжийн төслийг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

3/улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нь нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсөвт магадлал хийх, аудитын дүгнэлт гаргуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, саналаа 2025 оны нэгдүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах.

2.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг сайжруулж, олон улсын жишигт нийцүүлэх, үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх, ил тод байдлыг сайжруулахад чиглэсэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглал, менежментийг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр олон улсад нэр хүнд бүхий хуулийн этгээдтэй хамтран тэдгээрийн засаглалын шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж, үр дүнг тайлагнах;



2/Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэлийг харгалзан бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, үр ашгийг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах асуудлыг судалж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр хуулийн этгээдийг нэгтгэх, нийлүүлэх, өөрчлөн зохион байгуулах;

3/Төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэл, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах асуудлын талаар холбогдох санал боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

4/Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн мэдээллийг нийтэд мэдээлэх үйл ажиллагаанд хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох;

5/Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын болон Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх;

6/Төрийн банк болон санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааг олон улсын жишигт нийцсэн ногоон хөгжлийг дэмжих тусгайлсан чиг үүргээр шинэчлэн зохион байгуулж, агаар, орчны бохирдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй төсөл, хөтөлбөр, хэрэглээг урамшуулан дэмжсэн санхүүгийн бүтээгдэхүүний төрөл, хүртээмж, санхүүжилтийг нэмэгдүүлэх.

3.Төсвийн ил тод, үр ашигтай байдал, санхүүгийн хяналт, хариуцлагыг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч, холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлтийг 2025 оны хоёрдугаар улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/"бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр, хураамж" гэсэн тухайн төрийн байгууллагын өөрсдөө хийх боломжгүй, тусгай мэргэшил, үр чадвар шаардагдах, гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээг тухайн ажлын төрөл, цар хүрээ, мэргэжлийн үр чадвар, зах зээлийн үнэлгээнд үндэслэн Засгийн газрын санхүүгийн статистику гаргах аргачлал, загварт нийцүүлж, зардлын эдийн засгийн зүйл болон зориулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний ангиллаар нарийвчлан тодорхойлох, цаашид жилийн төсвийн тухай хуулийн тооцооллын хавсралтад нэмэлтээр тусгах;

2/төсвийн төслийг боловсруулахдаа төсвийн ерөнхийлөн захирагчид “бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр, хураамж” болон “бусад зардал” гэсэн зардлын ангиллаар төсөв зарцуулах болсон зайлшгүй шаардлага, гарах үр дүн, үр ашгийг тооцож байх;

3/олон улсын сайн туршлагад үндэслэн гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээнд хуулиар хязгаарлалт тогтоох, уг зардалд тавих шаардлагыг нэмэгдүүлэх, төрийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөнд тусгах, аудитын тайлангаар баталгаажуулах, олон нийтэд нээлттэй мэдээлэх асуудлын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

4.Төрийн байгууллагуудын мэдээллийн систем, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын программ хангамж, тоног төхөөрөмжийн худалдан авалт, ашиглалтыг сайжруулах, төсвийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, салбар хоорондын цахимжилтыг нэгдсэн удирдлагаар хангах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/төрийн байгууллагуудад ашиглаж байгаа мэдээллийн систем, программ хангамж, тоног төхөөрөмжийн ашиглалтын өнөөгийн байдал болон кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдалд аудит хийж тайланг 2025 оны нэгдүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах.

5.Нийслэл Улаанбаатар хотоос шилжин байрших боломжтой төрийн байгууллагуудыг орон нутаг дахь төрийн болон орон нутгийн өмчийн барилга, байгууламжид байрлуулах, нийслэлд чөлөөлөгдөх барилга байгууламжийн тоо байршил, зориулалтыг судлан жагсаалт гаргаж, Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд холбогдох Байнгын хороонд танилцуулж, шийдвэр гарсны дараа тэднийг худалдах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах.

6.Төсвийн зардлыг шууд нэмэгдүүлж, төсвийн тэнцэлд сөргөөр нөлөөлж байгаа хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжуудыг нэгтгэн судалж, 2025 оны нэгдүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах.

7.Төсвөөс олгож байгаа бүх төрлийн татаас, урамшууллын эдийн засагт үзүүлж буй нөлөөлөлд судалгаа, шинжилгээ хийж, эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих, төсвийн ачааллыг бууруулах зорилтуудыг уялдуулах санал боловсруулж, 2025 оны хоёрдугаар улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах.



8.Хууль тогтоомжид зааснаас бусад яамдын чиг үүрэгтэй давхацсан зөвлөл, хороо, комисс, төвүүдийг татан буулгаж, чиг үүргийг холбогдох яамдад шилжүүлэх.

9.Цэвэр эрчим хүч үйлдвэрлэх, хогноос сэргээгдэх эрчим хүч гаргаж авах асуудлыг зохицуулах, ногоон эрчим хүч, эдийн засгийг дэмжих хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх.

10.Төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжиж, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулж, холбогдох хууль тогтоомжийг Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх.

11.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Ц.Даваасүрэн/, Эдийн засгийн байнгын хороо /Р.Сэддорж/-нд тус тус даалгасугай.

12.Энэ тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.АМАРБАЯСГАЛАН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 53

Улаанбаатар
хот

“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-д нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 13 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” хэсэгт “-Ургамал хамгааллын газар” гэж нэмсүгэй.

2. Энэ тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН



Индриг Фолд на Урд Хорд на Дорнод

Урьдчилсан гэрээ

2024

Урьдчилсан гэрээний үндсэн дээр

«Индриг Фолд на Урд Хорд на Дорнод»
ХХК-ийн үйлдвэрлэлийн үйлдвэр
байгуулсан байна. 2024 оны 10 сар 15-нд

ХХК-ийн үйлдвэрлэлийн үйлдвэр байгуулсан байна. 2024 оны 10 сар 15-нд
Урьдчилсан гэрээний үндсэн дээр

«Индриг Фолд на Урд Хорд на Дорнод» ХХК-ийн үйлдвэрлэлийн үйлдвэр
байгуулсан байна. 2024 оны 10 сар 15-нд
Урьдчилсан гэрээний үндсэн дээр

..

Урьдчилсан гэрээний үндсэн дээр

2024



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 54

Улаанбаатар
хот

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэхэд тавих хяналтыг сайжруулж, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шийдвэрлэх;

2/Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн биелэлтэд үнэлгээ хийж, тусгай сан тус бүрийн зориулалт, төсөвлөлт, зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийлгэж аудитын тайланг, уг хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх;

3/гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдийн үр ашгийн эрэмбийг гаргаж, удаашралтай байгаа төслүүдийг цаашид хэрхэн шийдвэрлэх талаар санал боловсруулан 2025 оны хоёрдугаар улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах;

4/шинээр авах гадаад зээлийн санхүүжилтийг эдийн засгийн өсөлтийг дэмжих, бүсчилсэн хөгжлийн бодлого, томоохон дэд бүтцийн хөрөнгө оруулалтад чиглүүлж, цаашид хувийн хэвшил хийх боломжтой төслүүдийг гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй байх;

5/төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдэд үүссэн өр, авлага, зээлийн асуудалд дүн шинжилгээ хийж, тайланг 2025 оны нэгдүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах;



6/аудитын шалгалтаар илэрсэн аливаа зөрчлийн шинжтэй асуудал тус бүрийн хариуцлагын асуудлыг Төрийн аудитын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд нарийвчлан зохицуулах, холбогдох хууль хоорондын уялдааг хангах, хийдэл зөрчлийг арилгах хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх;

7/Хавдар судлалын үндэсний төвийн ажиллагааг өргөжүүлэх зорилгоор эмнэлгийн зориулалтын шаардлага хангасан барилгыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн санхүүгийн түрээс /лизинг/-ийн нөхцөлөөр өөрийн өмчлөлд бүрэн шилжүүлэн авах;

8/Америкийн Нэгдсэн Улстай байгуулсан агаарын харилцааны хэлэлцээрийн дагуу шууд нислэг хийх нөхцөл боломжийг бүрдүүлэх, үүнд шаардагдах нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтыг нэвтрүүлэх зорилгоор навигацийн орлогоос шаардлагатай санхүүжилтийг 2025 оны төсвийн жилд зарцуулах;

9/Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын харьяа шинээр баригдах хөрөнгө батлагдаагүй нэн шаардлагатай зарим газар, байгууллагуудад түрээсийн байр ашиглуулан үйл ажиллагаа явуулах.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Ц.Даваасүрэн/-нд даалгасугай.

4.Энэ тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.АМАРБАЯСГАЛАН

Индикс Folio_02 Ykda Hor&_02 Docidlog&

Ажлын гүйцэтгэл

№ 62

№ 62 – 69 Ажлын гүйцэтгэл 2024 он

Тус тусад нь ажлын гүйцэтгэл
2024 он 06 сар 14 өдөр
Ажлын гүйцэтгэл

Ажлын гүйцэтгэл 2024 он 06 сар 14 өдөр
Тус тусад нь ажлын гүйцэтгэл
2024 он 06 сар 14 өдөр

Тус тусад нь ажлын гүйцэтгэл
2024 он 06 сар 14 өдөр
Тус тусад нь ажлын гүйцэтгэл
2024 он 06 сар 14 өдөр

Тус тусад нь ажлын гүйцэтгэл
2024 он 06 сар 14 өдөр
Тус тусад нь ажлын гүйцэтгэл
2024 он 06 сар 14 өдөр

Тус тусад нь ажлын гүйцэтгэл
2024 он 06 сар 14 өдөр
Тус тусад нь ажлын гүйцэтгэл
2024 он 06 сар 14 өдөр

Тус тусад нь ажлын гүйцэтгэл
2024 он 06 сар 14 өдөр
Тус тусад нь ажлын гүйцэтгэл
2024 он 06 сар 14 өдөр

Тус тусад нь ажлын гүйцэтгэл
2024 он 06 сар 14 өдөр
Тус тусад нь ажлын гүйцэтгэл
2024 он 06 сар 14 өдөр

Тус тусад нь ажлын гүйцэтгэл
2024 он 06 сар 14 өдөр
Тус тусад нь ажлын гүйцэтгэл
2024 он 06 сар 14 өдөр



дээрх үндэстний дүр зураг нь үндсэндээ төрийн эдийн засгийн хөгжлийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Үндэстний дүр зураг нь төрийн эдийн засгийн хөгжлийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэнэ.

1/Үндэстний дүр зураг нь төрийн эдийн засгийн хөгжлийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Үндэстний дүр зураг нь төрийн эдийн засгийн хөгжлийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэнэ.

2/Үндэстний дүр зураг нь төрийн эдийн засгийн хөгжлийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Үндэстний дүр зураг нь төрийн эдийн засгийн хөгжлийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэнэ.

3/Үндэстний дүр зураг нь төрийн эдийн засгийн хөгжлийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Үндэстний дүр зураг нь төрийн эдийн засгийн хөгжлийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэнэ.

4/Үндэстний дүр зураг нь төрийн эдийн засгийн хөгжлийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Үндэстний дүр зураг нь төрийн эдийн засгийн хөгжлийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэнэ.

5/Үндэстний дүр зураг нь төрийн эдийн засгийн хөгжлийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Үндэстний дүр зураг нь төрийн эдийн засгийн хөгжлийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэнэ.

6/Үндэстний дүр зураг нь төрийн эдийн засгийн хөгжлийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Үндэстний дүр зураг нь төрийн эдийн засгийн хөгжлийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэнэ.

7/Үндэстний дүр зураг нь төрийн эдийн засгийн хөгжлийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Үндэстний дүр зураг нь төрийн эдийн засгийн хөгжлийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэнэ.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 12

Индекс: 200003